



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн  
2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2019/01/СТА-ТЭЗ

ЧОЙБАЛСАН ХОТ  
2019 он

---



## АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн:	АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ	2
Дорнод аймаг дахь	АУДИТ ХИЙГДСЭН ДОРНОД АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН	4
Төрийн аудитын газар	ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН	4
	АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН	4
Газрын дарга бөгөөд тэргүүлэх	АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН	4
аудиторын албан үүргийг түр	АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН	4
орлон гүйцэтгэгч:	НЭГТГЭСЭН ТАЙЛАН	4
Ц.Батбаяр	АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ НЭГТГЭСЭН ТАЙЛАН	5
	Товчилсон үгийн жагсаалт	6
Аудитын менежер:	Аудитын талаарх үндсэн мэдээлэл	7
В.Цэнгэлмаа	Санхүүгийн тайланг нэгтгэхэд баримталсан зарчим, аргачлал	10
	Санхүүгийн дотоод хяналт	11
Ахлах аудитор:	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар	12
	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн	13
Д.Нармандах	Нэг. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	13
Ж.Баяртуул	Хоёр. Авлага	14
	Гурав. Бараа материал	14
Аудитор:	Дөрөв. Үндсэн хөрөнгө	14
М.Ухаанбилэг	Тав. Өр төлбөр	14
	Зургаа. Засгийн газрын хувь оролцоо	15
	Долоо.Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн	15
	7.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудит	15
2019 оны 4 дугаар сар	7.2 төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудит	16
Уг тайланг УАГ-ын	7.3 Төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайланд хийсэн аудит	16
Цахим хуудаснаас үзнэ үү:	Найм. Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн залруулга	16
<a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Ёс. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, албан шаардлагын биелэлт	16
Аудитын тайлантай холбоотой	АУДИТЫН ДҮГНЭЛТ	17
асуудлаар нэмж тодруулах, асууж	АУДИТЫН ЗӨВЛӨМЖ	17
лавлах зүйл байвал 7058-4207	АУДИТЫН ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ	37
дугаарын утсаар харилцана уу.		
ХАЯГ:		
Дорнод аймаг		
ЗДТГ-ын II байр,		



УДИТЫН ГЭРЧИЛГЭЭ



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
М.БАДАМСҮРЭН ТАНАА

ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2019.04.20 № 257

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Дорнод аймгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорнод аймгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорнод аймгийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110519438



### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дугаар зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ц.БАТБАЯР





## АУДИТ ХИЙГДСЭН ДОРНОД АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

### АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

/мян.төг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2017оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		17,499,519.0	18,213,536.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	6,523,621.0	6,902,523.6
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	4,220,291.3	3,920,182.0
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	0.0	0.0
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	6,755,606.8	7,390,830.4
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		109,295,621.4	146,804,946.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	109,295,621.4	146,804,946.4
39100	Газар		0.0	0.0
39200	Биет хөрөнгө		108,658,396.0	130,129,751.8
39300	Биет бус хөрөнгө	13	637,225.4	16,675,194.6
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		126,795,140.4	165,018,482.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		3,948,518.6	3,827,808.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	537,293.4	416,583.0
41300	Өглөг	17а, 17б	537,293.4	416,583.0
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		3,411,225.2	3,411,225.2
42200	Урт хугацаат зээл	20а, 20б	3,411,225.2	3,411,225.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		122,846,621.8	161,190,674.1
51	Засгийн газрын хувь оролцоо		122,846,621.8	161,190,674.1
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		49,963,871.3	69,673,720.1
51200	Хуримтлагдсан үр дүн		55,495,093.8	50,666,924.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		17,387,656.8	40,850,029.5
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		126,795,140.4	165,018,482.3

### АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

/мян.төг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2017оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		71,719,711.6	81,585,421.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО		18,328,596.3	17,477,939.4
110	Орлогын албан татвар		10,896,887.2	10,695,295.9
1100	Хувь хүний орлогын албан татвар		11,800,849.6	11,572,345.5
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-903,962.4	-877,049.6
113	Хөрөнгийн албан татвар		954,131.6	1,016,488.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж		6,477,577.5	5,766,155.4



Торнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	48,566,982.7	58,282,422.3
120	Нийтлэг татварын бус орлого		9,824,246.0	15,146,855.4
121	Хөрөнгийн орлого		5,315,376.5	4,405,375.1
122	Тусламжийн орлого		56,396.4	0.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		33,370,963.8	38,730,191.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		4,824,132.6	5,825,059.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	65,440,500.5	73,416,748.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ		60,766,778.1	66,303,428.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		48,046,733.3	54,537,975.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		23,951,405.6	25,511,213.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		2,660,999.8	3,058,713.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		2,210,550.7	2,104,799.8
2104	Хангамж, бараа материалын зардал		1,479,218.8	5,608,284.2
2105	Нормативт зардал		3,117,739.7	2,316,246.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		586,235.7	689,312.6
2107	Томилолт, зочны зардал		234,124.5	173,363.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,149,246.1	1,653,643.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		12,657,212.4	13,422,398.6
212	ТАТААС		748,572.0	835,278.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		11,971,472.8	10,930,175.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		4,673,722.5	7,113,319.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		6,279,211.0	8,168,673.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		1,038,275.2	8,097,782.8
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		5,240,935.9	70,890.2

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

/МЯН.ТӨГ/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	119,425,149.0	119,425,149.0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,800,338.0	-1,800,338.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	117,624,810.9	117,624,810.9
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-19,125.0	-19,125.0
9	Тайлант үеийн үр дүн	5,240,935.9	5,240,935.9
10	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	122,846,621.8	122,846,621.8
11	2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	122,846,621.8	122,846,621.8
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-4,899,059.4	-4,899,059.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	117,947,562.5	117,947,562.5
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	23,462,372.7	23,462,372.7
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	19,709,848.8	19,709,848.8
19	Тайлант үеийн үр дүн	70,890.2	70,890.2
20	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	161,190,674.1	161,190,674.1



**АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ НЭГТГЭСЭН ТАЙЛАН**

/мян.төг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2017оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	64,282,172.4	71,956,447.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	18,325,206.4	17,477,939.4
110	Орлогын албан татвар	10,893,497.3	10,695,295.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	11,797,459.7	11,572,345.5
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-903,962.4	-877,049.6
113	Хөрөнгийн албан татвар	954,131.6	1,016,488.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	6,477,577.5	5,766,155.4
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,335,761.8	1,410,024.4
1181	Газрын төлбөр	885,971.7	643,205.7
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	4,207,687.7	3,704,015.3
1183	Бусад татвар	48,156.2	8,910.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	40,775,527.7	47,814,583.7
120	Нийтлэг татварын бус орлого	6,716,440.2	9,008,480.4
121	Хөрөнгийн орлого	112,046.6	75,911.5
122	Тусламжийн орлого	576,077.1	0.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	33,370,963.8	38,730,191.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,181,438.3	6,663,924.1
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	56,823,622.2	59,161,708.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	56,823,622.2	59,161,708.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	44,226,702.0	47,272,619.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	24,877,800.2	26,570,438.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,905,850.0	3,352,843.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,299,547.4	3,259,795.6
2104	Хангамж, бараа материалын зардал	2,036,763.5	2,368,639.2
2105	Нормативт зардал	2,511,498.3	2,619,170.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	667,960.1	975,561.8
2107	Томилолт, зочны зардал	237,713.3	173,383.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,377,881.2	1,831,407.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,311,688.0	6,121,378.6
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	748,572.0	835,278.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,848,348.2	11,053,810.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	7,458,550.2	12,794,738.9
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.0	0.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	5,397,391.1	12,063,658.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,397,391.1	12,063,658.3
2200	Дотоод эх үүсвэрээр	5,397,391.1	12,063,658.3
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-5,397,391.1	-12,063,658.3
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-911,275.6	-352,178.0
14	Бусад эх үүсвэр	0.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	911,275.6	352,178.0
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	0.0	0.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,149,883.5	378,902.6
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,373,737.5	6,523,621.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,523,621.0	6,902,523.6



## Товчилсон үгийн жагсаалт

АОУС	Аудитын олон улсын стандарт
БХӨТ	Богино хугацаат өр төлбөр
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ҮАГ	Үндэсний аудитыг газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
СХС	Сум хөгжүүлэх сан



## **АУДИТЫН ТАЛААРХ ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ**

### **Аудит хийсэн үндэслэл, хугацаа**

Үндэсний аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### **Аудитын зорилт, хамарсан хүрээ**

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг УСНББОУС, СТОУС болон бусад шаардлагын дагуу бэлтгэж, ажил гүйлгээ нь түүнийг зохицуулж буй хууль, тогтоомжийн хүрээнд хийгдэж, үнэн шударга илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангууд иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгыг тэдгээр тайланд хавсаргах ёстой. Эдгээр мэдээллийг Аудитын олон улсын стандартын дагуу сорьж шалгах нь аудитын горим бөгөөд хамарсан асуудлууд болно.

Төрийн аудитын байгууллага Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, санал дүгнэлт гаргахын өмнө Төсвийн тухай болон Төрийн аудитын тухай хуулийн дагуу төсвийн захирагчид, зарим төсөл, хөтөлбөр, сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

### **Аудитын арга зүй**

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг үндсэн шалгуур болгон хяналтын сорил, шинжилгээний горим гүйцэтгэж, түүврээр ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж, үнэлгээ өгөв.

### **Материаллаг байдлын түвшин**

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд төсөвт байгууллага, төрийн сан, төсөл, хөтөлбөр, сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлангууд нэгтгэгддэг тул материаллаг байдлын түвшинг Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын дүнгээс 2.0 хувь буюу 1,6 тэрбум төгрөгөөр тогтоосон болно.

## **САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН ЗАРЧИМ, АРГАЧЛАЛ**

Дорнод аймгийн Засаг дарга Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1, 54.2 дахь заалтын дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн



тайланг бэлтгэн гаргаж, хуульд заасан хугацаанд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-д заасны дагуу

- Санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан байгууллага хооронд үүссэн 56885,5 сая төгрөгийн давхардсан ажил гүйлгээ, орлого болон зардлыг цэвэрлэж,
- Санхүүгийн нэгтгэсэн тайланг төсөвт байгууллага, төсөл, хөтөлбөр, сан, төрийн сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төрлөөр ангилан тайлагнасан байна.

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн 14 төвлөрүүлэн захирагч, 147 төсвийн байгууллага, 44 орон нутгийн тусгай сан, 16 орон нутгийн өмчит хуулийн этгээд, нийт 221 санхүүгийн тайланг нэгтгэсэн байна. Чойбалсан, Сэргэлэн сумдын орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд нь тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй “Х” тайлан гаргасан байна.

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 16 орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэн ба

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2 –т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын санхүүгийн тайлан, Засгийн газрын шугамаар авч, ашиглаж байгаа хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг санхүүгийн нэгтгэсэн тайланд хамааруулна” гэж заасны дагуу 100 хувийн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайланг хамруулсан байна.

### **Санхүүгийн тайланг бэлтгэсэн суурь**

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг нягтлан бодох бүртгэлийн тохируулсан аккрузал суурийг хэрэглэж бэлтгэсэн байна.

### **Тайланг илэрхийлсэн мөнгөний нэгж**

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалтын дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлж, санхүүгийн нэгтгэсэн тайлан болон тодруулга тайланг мянган төгрөгөөр илэрхийлсэн байна.

### **Санхүүгийн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн**

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргах зорилтын хүрээнд үе шаттай ажлуудыг хэрэгжүүлсэн байна. Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулсан Сангийн сайдын 341 дүгээр тушаалаар



оатлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

<b>А. Үндсэн тайлан</b>	<b>Б. Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан</b>	<b>В. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар, тодруулга</b>
Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	НББ-ийн бодлого, зарчим 3-21 дүгээр тодруулгууд
Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	1а, 1б, 2а, 2б тодруулга
Төсвийн ерөнхийлөн захирагчийн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	
Төсвийн ерөнхийлөн захирагчийн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	

## Нягтлан бодох бүртгэлийн зарчим

## Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь дараах зүйлсээс бүрдсэн байна. Үүнд:

- Төрийн сангийн нэгдсэн дансны Монгол банк дахь үлдэгдэл;
- Төсөвт байгууллага, төсөл, хөтөлбөрийн арилжааны банк дахь үлдэгдэл;
- Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн арилжааны банк дахь үлдэгдэл;
- Кассад байгаа бэлэн мөнгө;

Мөнгө ба түүнтэй адилтгах мөнгөн хөрөнгө нь богино хугацаатай, өндөр хөрвөх чадвартай хөрөнгө бөгөөд бэлэн мөнгө рүү түргэн хөрвөх чадвартай, үнэ цэнээ алдах эрсдэл багатай хөрөнгө байна.

## Авлага

Авлага нь богино хугацаат дансны авлага, зээлийн авлагаас бүрдсэн байна.

## Бараа материал

Бараа материалын өртгийг эхэлж авснаа эхэлж зарлагдах аргаар тодорхойлжээ.



## **Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийг өртгөөр нь болон Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар баталсан “Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал”-ын дагуу газар, барилга байгууламжийг дахин үнэлсэн дүнгээр хүлээн зөвшөөрсөн.

Төсвийн захирагчид 2018 онд үндсэн хөрөнгөд УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө” стандартын дагуу элэгдэл байгуулжээ.

## **Биет бус хөрөнгө**

Биет бус хөрөнгө гэдэг нь биет шинж чанаргүй боловч ирээдүйд түүнээс өгөөж хүртэхийн тулд гаргасан зарлага юм.

## **Богино хугацаат өр**

Богино хугацаат өр төлбөр нь нэг жилийн дотор барагдуулах ёстой өр төлбөрийг илэрхийлнэ.

## **Урт хугацаат өр төлбөр**

Урт хугацаат өр төлбөр гэдэг нь нэг жилээс дээш хугацаанд барагдуулах үүрэг хариуцлага юм.

## **Орлого хүлээн зөвшөөрөлт**

Арилжааны бус орлого болох татвар, хураамж, торгууль, шимтгэлийг цуглуулсан үед нь, харин бараа, үйлчилгээг төлбөртэйгөөр хүргэсэн үед арилжааны (хэрэгжсэн) орлогыг тохируулсан аккрузал сууриар хүлээн зөвшөөрсөн байна.

## **Зардал**

Нягтлан бодох бүртгэлийн аккрузал зарчмын дагуу гарсан үед нь хүлээн зөвшөөрсөн байна.

## **Дотоод аудит**

Төсвийн ерөнхийлөн захирагчид Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 69.2-т “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албыг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангана” гэж заасны дагуу Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар нь дотоод аудитын албадыг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангадаг байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар жил бүр илэрсэн алдаа, зөрчлийн дүн буурахгүй байгаа нь санхүүгийн хяналт, аудитын албаны үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн ажилтнуудын тогтвор суурьшил, мэдлэг ур чадвар хангалтгүй байгаатай холбоотой байна.



## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР

### Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан нь мөнгөн хөрөнгө 6,902.5 сая, авлага 3,920.2 сая, бараа материал 7,390.8 сая, үндсэн хөрөнгө 146,804.9 сая, нийт 165,018.5 сая төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар өмнөх оноос эргэлтийн хөрөнгө 714.0 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгө 37,509.3 сая төгрөгөөр нэмэгдэж, нийт хөрөнгө болон өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн өмнөх оноос 38,313.3 сая төгрөг буюу 30.1 хувиар нэмэгдсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар баталсан “Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал”-ын дагуу газар, барилга байгууламжийг дахин үнэлсэнтэй холбоотой байна.


Санхүүгийн тайлангийн шинжилгээгээр тайлант онд нийт хөрөнгийн 11.0 хувийг эргэлтийн хөрөнгө, 89 хувийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж байна.

### Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангаар нийт орлого нь нийт зардлаас 70.9 сая төгрөгөө илүү байна.

Нийт зардал 73,416.7 сая төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос урсгал зардал 1,615.1 сая төгрөг, хөрөнгийн зардал 6,361,1 сая төгрөгөөр буюу 12.2 хувиар өссөн байгаа нь төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлсэн мөн хөрөнгө оруулалтыг өмнөх оноос нэмэгдүүлэн баталсантай холбоотой байна.

Төсвийн зарлагын гүйцэтгэлийг нийт дүнд харьцуулбал:





Байгууллагын төрлөөрх санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангаар орон нутгийн өмчит хуулийн этгээд нийт 118,7 сая төгрөгийн ашигтай ажиллаж, төрийн сангийн нийт зардал нь орлогоос 441.0 сая төгрөгөөр илүү байна.

### Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайланд засгийн газрын оруулсан капитал 19,709.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал”-ын дагуу эзэмшил, ашиглах эрхийн газрыг үнэлэн хөрөнгийн бүртгэл тайланд тусгасантай холбоотой байна.

### Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлангаар мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 378.9 сая төгрөгөөр буюу 5.6 хувиар өссөнд, хугацаа хэтэрсэн авлага их байгаагаас шалтгаалж сумдууд СХС-гийн зээлийг олгоогүй нь нөлөөлсөн байна.

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА, АУДИТЫН ДҮН

### Нэг: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 6,902.5 сая төгрөгт хүрч, өмнөх оноос 378.9 сая төгрөг буюу 5.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	/мян.төг/ Дүнд эзлэх хувь
<b>1.Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	<b>10,923.8</b>	<b>10,773.3</b>	<b>-150.5</b>	<b>0,2</b>
<b>2. Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>6,512,697.2</b>	<b>6,891,750.6</b>	<b>+379,053.0</b>	<b>99,8</b>
2.1 Төрийн сангийн харилцах	4,603,263.4	4,796,742.8	+193,479.4	69,5
2.2 Арилжааны банк дахь харилцах	1,909,433.7	2,095,007.4	+185,573.6	30,3
<b>Нийт дүн</b>	<b>6,523,621,0</b>	<b>6,902,523.6</b>	<b>+378,902.6</b>	<b>100,0</b>

Нийт мөнгөн хөрөнгийн 69.5 хувь буюу 4,796.7 сая төгрөг төрийн санд, 30.3 хувь буюу 2,095.0 сая төгрөг арилжааны банканд, 0,2 хувь буюу 10.8 сая төгрөг кассанд байна.

Татвар болон нийгмийн даатгалын хэлтсийн орлого төвлөрүүлдэг “Тэг” үлдэгдэлтэй дансдын орлогыг сар бүрийн эцэст төвлөрүүлэн тооцоо нийлж баталгаажуулан ажилласан байна.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн нийт үлдэгдлийн 16.2 хувь буюу 1,103.9 сая төгрөг төсөвт байгууллагууд, 43.1 хувь буюу 2,983.4 сая төгрөг төрийн санд, 10.3 хувь буюу 715.2 сая төгрөг төсөл сангуудад, 30.4 хувь буюу 2,099.9 сая төгрөгийг орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд бүртгэн тайлагнасан байна.



## хоёр: Авлага

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт авлагын эхний үлдэгдэл 4,220.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 3,920.2 сая төгрөгөөр тайлагнаж өмнөх онтой харьцуулахад 313.4 сая төгрөгөөр буурсан байна.

Нийт авлагын 3,304.8 сая төгрөг 84.6 хувийг төсөвт байгууллага, 79.6 сая төгрөг буюу 2.0 хувийг төсөл, сан, 123.9 сая төгрөг буюу 3.2 хувийг төрийн сан, 398.6 сая төгрөг буюу 10.2 хувийг төрийн болон орон өмчит хуулийн этгээдийн авлага эзэлж байна.

### Аудитын илрүүлэлт:

- Нийт авлагын 3,704,6 сая төгрөг буюу 78,4 хувийг Сум хөгжлийн сан болон мал хамгаалах сангаас олгосон зээл, зээлийн хүүгийн эзэлж байгаагаас хугацаа хэтэрсэн 1,489.8 сая төгрөгийн авлага байгаа нь өмнөх оноос 79.8 сая төгрөгөөр өссөн байна. /сум хөгжүүлэх сан -1,382.3 сая төгрөг, мал хамгаалах сан-107.5 сая төгрөг/
- Хөрөнгө худалдан авах урьдчилгаанд олгосон 11,700.0 мянган төгрөгийг шууд зардалд бүртгэсэн зөрчлийг нэгтгэсэн тайланд залруулж авлагаар тусгуулсан.

## Гурав: Бараа материал

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь бараа материалын эхний үлдэгдэл 6,755.6 сая төгрөг байснаас 635.2 сая төгрөгөөр нэмэгдэн 7,390.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Үүнээс 7,112.0 сая төгрөг буюу 96.2 хувийг төсөвт байгууллага, 278.8 сая төгрөг буюу 3.8 хувийг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн бараа материал тус тус эзэлж байна.

## Дөрөв: Үндсэн хөрөнгө

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл хуримтлагдсан элэгдлийг хассан цэвэр дүнгээр 109,295.6 сая төгрөг байснаас 37,509.3 сая төгрөгөөр өсөж, тайлант оны эцэст 146,804.9 сая төгрөг болсон байна.

Үндсэн хөрөнгийн нийт үлдэгдлийн 86.9 хувь буюу 127,579.1 сая төгрөг төсөвт байгууллагууд, 13.1 хувь буюу 19,225.8 сая төгрөгийг орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд бүртгэн тайлагнасан байна.

Нийт хөрөнгийн 88.6 хувийг биет хөрөнгө, 11.4 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна.

### Аудитын илрүүлэлт:

- Нэмэлт санхүүжилтээр худалдан авсан 3,950.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 5,250.0 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг зардлаар бүртгэснийг аудитын явцад залруулж хөрөнгөөр бүртгүүлсэн.

## Тав: Өр төлбөр

Нийт өр төлбөр оны эхэнд 3,948.5 сая төгрөг байснаас 120.7 сая төгрөгөөр буурч 3,827.8 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.



хүснэгт 2. Нийт өр, төлбөрийн дансны ангилал

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	/мян.төг/ Дүнд эзлэх хувь
<b>Нийт өр төлбөрийн дүн</b>	<b>3,948,518.6</b>	<b>3,827,808.2</b>	<b>-120,710.4</b>	<b>100</b>
Богино хугацаат өр төлбөр дүн	537,293.4	416,582.9	-120,710.4	10.9
Урт хугацаат өр төлбөр дүн	3,411,225.2	3,411,225.2	-	89.1
<i>Үүнээс байгууллагын төрлөөр:</i>				
Төсөвт байгууллага	537,293.4	416,582.9	-120,710.4	10.9
ТӨҮГ болон ОНӨҮГ	3,411,225.2	3,411,225.2		89.1

Урт хугацаат өр төлбөр 3,411.2 сая төгрөг буюу нийт өр төлбөрийн 89.1 хувь, богино хугацаат өр төлбөр 416.9 сая төгрөг буюу 10.9 хувийг тус тус эзлэж байгаа бөгөөд нийт өр төлбөр 120.7 сая төгрөгөөр буюу 22.5 хувиар буурсан байна.

**Аудитын илрүүлэлт:**

- *ТЕЗ-ийн харьяаны орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын Азийн хөгжлийн банкнаас авсан урт хугацаат зээлийн өглөг 3,411.2 сая төгрөг нь анхны дүнгээс өөрчлөгдөөгүй, байгаа бөгөөд гэрээнд зээлийн хүүг жилд 2 удаа, үндсэн төлбөрийг 2010 оноос эхлэн төлөхөөр тусгасан ч өнөөдрийг хүртэл хүү болон зээлийн эргэн төлөлт хийгдээгүй, зээлийн хүүгийн өглөгийг тооцож бүртгэлд тусгаагүй байна.*

**Зургаа: Засгийн газрын хувь оролцоо**

Дорнод аймгийн ТЕЗ-ийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь засгийн газрын хувь оролцооны нийт дүн 161,190.7 сая төгрөг байгаа нь оны эхний үлдэгдлээс 31.2 хувиар өссөнд Засгийн газрын сан 19,709.8 сая төгрөг, дахин үнэлгээний зөрүү 23,462.3 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

**Аудитын илрүүлэлт:**

- *Хөрөнгийн дахин үнэлгээг алдаатай тайлагнаснаас шалтгаалж тайлант үеийн үр дүнг 85.0 сая төгрөгөөр дутуу, дахин үнэлгээний зөрүүг 94.2 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн байсныг нэгтгэсэн тайланд залруулсан.*

**Долоо: Төсвийн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн**

**7.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн тайлангийн аудит**

Аудитаар нийт 1,865.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад 865.1 сая төгрөгийн материаллаг алдааг залруулж, 343.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд 18 албан шаардлага хүргүүлж, материаллаг бус зөрчил, дутагдлыг арилгах 180.0 сая төгрөгийн 13 зөвлөмж өгч ажилласан.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17.3, Төсвийн тухай хуулийн 25.2 дахь заалтуудыг зөрчин 35.5 сая төгрөгийн хандивыг авч захиран зарцуулсан асуудлыг Авлигатай тэмцэх газарт шалгуулахаар шилжүүлсэн. /Баяндун сумын Засаг дарга 27.5 сая төгрөг, Хөлөнбуйр сумын Засаг дарга 6.0 сая төгрөг, Булган сумын Засаг дарга 2.0 сая төгрөг/

Тайлант хугацаанд төсвийн 14 төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийн “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн.



## 7.2 Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудит

ТШЗ-дын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 3,975.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад 1,205.4 сая төгрөгийн материаллаг алдааг залруулж, 22.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд 30 төлбөрийн акт тогтоож, 1,431.4 сая төгрөгийн алдаа, зөрчилд 36 албан шаардлага хүргүүлж, материаллаг бус зөрчил, дутагдлыг арилгах 1,329.0 сая төгрөгийн 72 зөвлөмж өгч ажилласан.

Тайлант хугацаанд ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний ТШЗ-ийн 101 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 2 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, 1 байгууллагын санхүүгийн тайланд “Сөрөг” санал дүгнэлт өгсөн. Үүнээс:

- Хязгаарлалттай дүгнэлт – Гурванзагал сумын ИТХ, ЗДТГ
- Сөрөг дүгнэлт - Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар

## 7.3 Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайланд хийсэн аудит

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 6,046.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 4,046.2 тэрбум төгрөгийн материаллаг алдааг санхүүгийн тайланд залруулж, 1.1 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 1,229.4 сая төгрөгийн 6 албан шаардлага өгч, 132.6 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 13 зөвлөмж өгсөн.

Аудитад хамрагдсан нийт 14 орон нутгийн өмчит хуулийн этгээдээс 13 нь “Зөрчилгүй”, Чойбалсан хөгжил ОНӨААН “Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан.

## Найм. Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн залруулга

Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд 11.7 сая төгрөгөөр авлага, 9.2 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, тайлант үеийн үр дүнг 85.0 сая төгрөгөөр дутуу, хөрөнгийн дахин үнэлгээг 94.2 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн байсныг залруулсан болно.

## Ес: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөвлөмж өгөгдсөнөөс биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 75 хувьтай байна.

*Сумдын эмийн эргэлтийн сангууд тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй, нийт 43.7 сая төгрөгийн авлага, 64.6 сая төгрөгийн өглөгтэй байна. Нийт авлагын 32.7 сая төгрөг буюу 74.8 хувь нь эмийн санчдаас авах он дамжсан авлага, мөн нийт өглөгийн дүн нийт хөрөнгөөс 7,7 хувиар давсан байна. СХС-гаас олгосон зээлийн үлдэгдэл 3.4 тэрбум төгрөг байгаа бөгөөд үүнээс эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн 1.4 тэрбум төгрөгийн авлагатай байна. Хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн авлага нийт авлагын 34.0 хувийг эзэлж байсан.*

*Иймд Эрүүл мэндийн яамнаас 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 7/153 дугаар албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн дагуу сумын эмийн эргэлтийн сангуудыг эрүүл мэндийн төвд нэгтгэх, сангуудын авлага, өглөгийг барагдуулж хэвийн үйл ажиллагааг ханган ажиллах аудитын зөвлөмж өгснийг одоог хүртэл хэрэгжүүлэн ажиллаагүй байна.*



## **АУДИТЫН ДҮГНЭЛТ**

Бид Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

## **АУДИТЫН ЗӨВЛӨМЖ**

1. Сум хөгжүүлэх сан болон мал хамгаалах сангийн төлөгдөөгүй зээлийн талаарх шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийг хангуулахад анхаарч, хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг бууруулах.
2. Санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгагдсан урт хугацаат зээлийн өглөг болох орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт бүртгэлтэй 3.4 тэрбум төгрөгийн зээл болон зээлийн хүүгийн эргэн төлөлтийг бүртгэлд тусгах асуудлыг холбогдох шатны байгууллагад хандан шийдвэрлүүлэх,
3. Санхүүгийн ажилтнуудын мэргэшүүлэх сургалтуудыг үр дүнтэй тогтмолжуулан, мэдлэг, ур чадварыг чадавхжуулахад анхаарч ажиллах.
4. Өөрийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчил, дутагдлыг арилган, аудитын зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих, илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх арга хэмжээ авах.

